



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, нийт 132,124,464.26 (нэг зуун гучин хоёр сая нэг зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун жаран дөрвөн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 123,232,475.49 (нэг зуун хорин гурван сая хоёр зуун гучин хоёр мянга дөрвөн зуун далан таван төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт ирүүлэх.

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
268 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2023 оны 679 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Тоёота Вохи, 02-96 УБҮ, AZR600045172	2002/2010	12,300,000.00	12,300,000.00	-	4,000,000.00	2,000,000.00
2	Ниссан алтима, 02-96 УНГ, 1N4AL11D64C121726	2004/2010	6,746,666.66	6,746,666.66	-	1,500,000.00	750,000.00
3	Ниссан теана, 09-69 УНТ, LGBF1AE037R007674	2007/2007	44,391,653.00	44,391,653.00	-	2,500,000.00	1,250,000.00
4	Ниссан теана, 05-78 УНҮ, LGBF1AE018R013538	2007/2008	6,000,000.00	4,249,999.98	1,750,000.02	2,500,000.00	1,250,000.00
5	Тоёота гранд марк-2, 63-99 УБВ, GX1006000810	2000/2007	15,313,414.60	15,313,414.60	-	2,000,000.00	1,000,000.00
6	Хьюндай соната-5, 44-19 УНҮ, KMNEM41BPH140068	2004/2004	25,015,200.00	25,015,200.00	-	1,000,000.00	500,000.00
7	Ниссан теана, 04-82 УБЗ, JNIBAUJ32Z0000116	2008/2008	22,357,530.00	15,215,541.25	7,141,988.75	8,100,000.00	4,050,000.00
	Нийт үнэ		132,124,464.26 (нэг зуун гучин хоёр сая нэг зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун жаран дөрвөн төгрөг хорин зургаан мөнгө)	123,232,475.49 (нэг зуун хорин гурван сая хоёр зуун гучин хоёр мянга дөрвөн зуун далан таван төгрөг дөчин есөн мөнгө)	8,891,988.77 (найман сая найман зуун ерэн нэгэн мянга есөн зуун наян найман төгрөг далан долоон мөнгө)	21,600,000.00 (хорин нэгэн сая зургаан зуун мянга)	10,800,000.00 (арван сая найман зуун мянга)